

ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

Ерөнхий мэдээлэл

Болгар улс одоогоор зөвхөн үндэсний виз олгож байгаа тул уг виз нь Шенгений бүс нутагт нэвтрэх эрхийг олгохгүй.

90 хүртэлх хоногийн шенгений визтэй хүмүүс болгарын виз авах шаардлагагүй

Бүгд Найрамдах Болгар Улсын Сайд нарын зөвлөлийн 2012 оны 1-р сарын 25-ны өдрийн шийдвэрийн дагуу хүчин төгөлдөр шенгений визтэй хүмүүст Болгар улс Шенгений бүсэд бүрэн нэгдэх өдрийг хүртэл нэг талт визгүй зорчих журам үйлчилнэ. Тэдгээр хүмүүс Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэрт анх нэвтрэн орсон өдрөөс эхлэн 6 сар бүрийн хүрээнд 3 сараас ихгүй хугацаагаар нэвтрэх болон байх эрхтэй бөгөөд болгарын богино хугацааны виз авах шаардлагагүй юм. Уг шийдвэр 2012 оны 1-р сарын 31-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

Визийн ангилал

ТРАНЗИТ НИСЛЭГИЙН “А” ВИЗ

Транзит нислэгийн “А” визийг гадаад улсруу зорчиход хүчинтэй бичиг баримттай /гадаад паспорт/ буюу зохих журмын дагуу олгогдсон түүнийг орлох бичиг баримттай гадаадын иргэнд олгоно.

- **“А” визийн төрлүүд**

Транзит нислэгийн виз нь нэг, хоёр эсвэл олон (ховор тохиолдолд) удаагийнх байна. Олон удаагийнх нь олгосон өдрөөс хойш 3 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

- **“А” визийг олгох тохиолдлууд**

Транзит нислэгийн виз бүхий гадаадын иргэн онгоц түр буудаллах болон өөр улсруу нислэгийг үргэлжлүүлэх зорилгоор онгоц сэлгэх үед олон улсын транзит бүсээр дайран өнгөрөх болон тус бүсэд байх эрхтэй.

Транзит нислэгийн визтэй гадаадын иргэн олон улсын нислэгийн транзит танхимаас гарах эрхгүй юм.

- **“А” виз хүсэн мэдүүлэхэд хавсаргах бичиг баримтууд**

“А” виз олгохыг хүсэх тохиолдолд мэдүүлэгт хавсарган бүрдүүлэх бичиг баримтууд:

1. Хүчинтэй гадаад паспорт;
2. Гадаад паспортын үндсэн мэдээлэл бүхий нүүр хуудасны хуулбар болон маршрутын дагуу очих эцсийн цэг хүртэлх дараа дараагийн улсад нэвтрэх зөвшөөрөл бүхий /хэрэв шаардлагатай бол/ ба/буюу өөр виз дарагдсан хуудаснуудын хуулбар;
3. Паспортын форматтай өнгөт цээж зураг (сүүлийн хагас жилд авахуулсан);
4. Онгоцны билетийн захиалга.

Транзит нислэгийн виз олгогдохоос өмнө билетийг хуулбарын хамт авчирна.

БОГИНО ХУГАЦААНЫ “С” ВИЗ

I. Транзит дамжин өнгөрөх “С” виз

- **Олгох тохиолдлууд**

Транзитаар дамжин өнгөрөх зориулалттай богино хугацааны визийг хэрэв шаардагддаг бол тухайн өөр улсуу зорчих виз авсан ба БНБУ-ын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх хүсэлтэй гадаадын иргэнд олгоно.

Транзитаар дамжин өнгөрөх виз нь гадаадын иргэнд тус бүр хоёр өдрийн хугацаатайгаар нэг, хоёр, эсвэл олон удаа (ховор тохиолдолд) транзитаар дамжин өнгөрөх эрх олгоно. Уг визний хүчинтэй хугацаа 12 хүртэл сар байж болно.

- **Дамжин өнгөрөх хоногийн тоо**

Транзитаар дамжин өнгөрөх визээр Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэр дээр өнгөрүүлэх нийт хоногийн тоо эхний удаа орсон өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд 90 хоногоос хэтрэхгүй байна.

- **“Транзитаар дамжин өнгөрөх” үйлдлийн тодорхойлолт**

Транзитаар дамжин өнгөрөх үйлдлийн үндсэн нөхцөл нь Бүгд Найрамдах Болгар Улсын нэг улстай хиллэж буй хилээр нэвтрэн ороод өөр нэг улстай хиллэх хилээр дамжин гарах юм.

Нисэх онгоцны буудлаар дамжин өнгөрөх нь онцгой тохиолдолд орох бөгөөд нэг улсаас нисэж ирээд хоёр хоногийн дотор өөр нэг улсуу нисэх бол транзитаар дамжин өнгөрөх явдал юм.

- **Транзитаар дамжин өнгөрөх виз шаардагдахгүй тохиолдлууд**

Дараах бичиг баримтуудын аль нэгийг бүрдүүлсэн гуравдагч орны иргэдэд транзитаар дамжин өнгөрөх виз шаардагдахгүй ба үүнд:

- шенгений бүсийн аль нэг орноос олгогдсон шенгений /нэгдсэн виз/, удаан хугацаагаар зорчих виз, оршин суух зөвшөөрөл;
- Румын, Кипр улсаас олгосон богино хугацааны үндэсний виз, удаан хугацаагаар зорчих виз, оршин суух зөвшөөрөл;
- Лихтенштейн улсын оршин суух зөвшөөрөл

Зөвхөн транзитаар дамжин өнгөрөх зорилгоор транзит хийх нөхцлийн дагуу дамжин өнгөрөх тохиолдолд визгүйгээр дамжин өнгөрөх эрх олгогдоно.

- **“С” виз хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтууд**

Транзитаар дамжин өнгөрөх виз олгохыг хүсэн мэдүүлэхэд дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Гадаадад зорчиход хүчинтэй баримт бичиг /Хүчинтэй гадаад паспорт/;
2. Гадаад паспортын үндсэн мэдээлэл бүхий нүүр хуудасны хуулбар болон маршрутын дагуу очих эцсийн цэг хүртэлх дараа дараагийн улсад нэвтрэх зөвшөөрөл /хэрэв шаардлагатай бол/ бүхий ба/буюу өөр виз дарагдсан хуудаснуудын хуулбар;
3. Бүрэн бөглөсөн виз хүсэх маягт ба гадаад паспортын форматтай буюу 3,5 x 4,5 хэмжээтэй нэг хувь өнгөт зураг;
4. Транзитаар дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн захиалгын баталгаа болон тэдгээр бичиг баримтуудын хуулбар ба/буюу аялалыг үргэлжлүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгө санхүүгийн боломжтой болохыг гэрчлэх баримт;
5. Транзитаар дамжин өнгөрөх бүрт хамгийн багадаа 50 евро, эсвэл түүнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар шаардлагатай хөрөнгө санхүүгийн чадвартай болохыг гэрчлэх баримт ба хэрэв газраар өөрийн тээврийн хэрэгслээр транзит хийх бол хамгийн багадаа 200 евро буюу эсвэл түүнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар нэмэлт хөрөнгийн чадвартай тухай баримт;
6. Европын холбооны нутаг дэвсгэр дээр даатгалын үйл ажиллагаа явуулах эрхийн лицензтэй даатгалын байгууллагаас олгосон хамгийн багадаа 30 мянган еврогийн баталгаа

гаргаж чадах хүчинтэй даатгалын баримт, түүний хуулбар. Транзитаар дамжин өнгөрөх бүрт уг даатгал нь эх оронд нь буцаах, эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэх болон эмчилгээ хийх шаардлагатай үед зардлыг нөхөх боломжтой байна.

II. Урьдчилан төлөвлөгдсөн зорилгот “С” виз

• Олгох тохиолдлууд

Урьдчилан төлөвлөгдсөн богино хугацаагаар зорчих визийг 6 сарын дотор эхлэн орсноос хойш нийт 90 хүртэл хоног байх эрхтэйгээр нэг, хоёр, эсвэл олон удаа орох гадаадын иргэнд олгоно.

• Олон удаа орж гарах эрхтэй богино хугацааны виз

Олон удаа орж гарах богино хугацааны виз нь 12 хүртэлх сарын хугацаатай байж болох ба зарим маш ховор тохиолдолд 5 жил хүртэлх хугацаатай байна.

Нэг жил хүртэлх хугацаатай олон удаа орж гарах эрхтэй визийг өмнөх жилд богино хугацааны визээр Бүгд Найрамдах Болгар Улсад зохих хууль журмынх нь дагуу зорчсон болон оршин суусан нөхцөлд ба мөн олон удаа орох эрхтэй виз хүсэх үндэслэлтэй гадаадын иргэнд олгож болно.

5 жилээс дээшгүй хугацаатай олон удаа орж гарах эрхтэй визийг өмнөх 2 жилд нэг жил хүртэлх хугацаатай олон удаа орж гарах эрхтэй визээр Бүгд Найрамдах Болгар Улсад зохих хууль журмынх нь дагуу зорчсон болон оршин суусан нөхцөлд ба мөн олон удаа орох эрхтэй виз хүсэх үндэслэлтэй хэвээр байгаа гадаадын иргэнд олгож болно.

Олон удаа орж гарах эрхтэй богино хугацааны визийг дараах нөхцлүүдийн аль нэгийг хангаж буй гадаадын иргэнд олгож болно:

1. зохих Худалдааны хуулийн дагуу аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэж буй болгарын иргэн эсвэл хуулийн этгээдтэй байнгын ажил хэргийн холбоотой;
2. Аж ахуйн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаа эрхэлдэг болгарын хуулийн этгээдтэй байнгын ажил хэргийн холбоотой;
3. Хөрөнгө оруулалтыг дэмжих хуулийн 24 дүгээр заалтад дурьдсан гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газартай байнгын ажил хэргийн холбоотой;
4. Бүгд Найрамдах Болгар Улстай холбоотой хоёр талын харилцааны хөгжилд хувийн зүгээс ихээхэн хувь нэмэр оруулсан;
5. Бүгд Найрамдах Болгар Улс дахь гадаадын иргэдийн тухай хуулийн дагуу болгарын иргэний гэр бүлийн гишүүн бол;
6. Бүгд Найрамдах Болгар Улсад удаан хугацаагаар гэр бүлээрээ оршин суугаа Европын холбооны улсын, Европын эдийн засгийн бүсийн аль нэг улсын эсвэл Швейцарын холбооны улсын иргэний гэр бүлийн гишүүн бол;
7. Бүгд Найрамдах Болгар Улсад удаан хугацаагаар оршин суухдаа өөрийн байнгын оршин суух газрыг хэвээр хадгалан үлдээсэн гадаадын иргэний гэр бүлийн гишүүн бол;
8. олон улсын авто замын тээврийн хэрэгслийн жолооч, эсвэл төмөр замын зорчигч болон ачааны тээврийн хэрэгслийн жолоодлогын багийн гишүүн бол.

• Богино хугацааны виз хүсэхэд бүрдүүлэх бичиг баримтууд

Богино хугацааны виз олгохыг хүсэн мэдүүлэхэд дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Гадаадад зорчиход хүчинтэй баримт бичиг /Хүчинтэй гадаад паспорт/;
2. Гадаад паспортын үндсэн мэдээлэл бүхий нүүр хуудасны хуулбар болон өөр виз дарагдсан хуудасны ба/буюу орох зөвшөөрлийн хуулбар;
3. Бүрэн бөглөсөн виз хүсэх маягт ба 3,5 x 4,5 хэмжээтэй гадаад паспортын форматтай нэг хувь өнгөт зураг;

4. Виз хүсэх үндэслэл болох баримт бичиг болон түүний хуулбар;
5. Мэдүүлэгт хүссэн өдөр бүрт хамгийн багадаа 50 евро, эсвэл түүнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар шаардлагатай хөрөнгө санхүүгийн чадвартай болохыг гэрчлэх баримт /банкны баримт/ байх ба нийт дүн 500 еврогоос багагүй байх ёстой буюу эсвэл түүнтэй тэнцэх чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар байж болох бөгөөд үгүй бол аялал жуулчлалын үйлчилгээний төлбөрийг бүрэн төлсөн баримт байна;
6. Мэдүүлэгт хүссэн хоног бүрт 50 еврогоос багагүй, эсвэл чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар түүнтэй тэнцэх хэмжээний шаардлагатай хөрөнгө санхүүгийн чадвартай болохыг гэрчлэх баримт /банкны баримт/, эсвэл жуулчлалын хэлбэрээр хоноглох байрны төлбөрийг урьдчилан төлсөн тухай баримт, эсвэл Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэр дээр байх хугацаанд тухайн гадаадын иргэний гаргах зардлыг бүрэн хариуцах тухай батласан хувь хүн, хуулийн этгээдийн урилга;
7. Болгар улсыг орхин явахад шаардагдах хөрөнгө санхүүгийн чадвартайг баталсан баримт буюу эсвэл хоёр талын тасалбартай байх ба хэрэв хувийн тээврийн хэрэгслээр орсон тохиолдолд 100 еврогоос багагүй буюу эсвэл чөлөөтэй хөрвөх чадвартай өөр валютаар түүнтэй тэнцэх хөрөнгөтэй болохыг гэрчлэх баримт;
8. Европын холбооны нутаг дэвсгэр дээр даатгалын үйл ажиллагаа явуулах эрхийн лицензтэй даатгалын байгууллагаас олгосон хамгийн багадаа 30 мянган еврогийн баталгаа гаргаж чадах хүчинтэй даатгалын баримт, түүний хуулбар. Уг даатгалын баримт Болгарт байх хугацаанд эх оронд нь буцаах, эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэх болон яаралтай эмчилгээ хийх шаардлагатай үед зардлыг нөхөх боломжтой байна. Богино хугацааны олон удаа орж гарах виз мэдүүлэгч нь зөвхөн зорчихоор төлөвлөсөн эхний аялалын хугацааг хамруулан даатгуулсан байна.

- **Урилга**

Хувь хүн гадаадын иргэнийг Бүгд Найрамдах Болгар Улсад богино хугацаагаар **хувийн зорилгоор** виз мэдүүлэн зорчихыг урьсан урилга нь тусгай маягт байх ба нотариатаар болон гадаадын иргэдийг хянан шалгах байгууллагаас /Болгарын Дотоод хэргийн яамны “Миграция” газар/ баталгаажуулсан байна. Урилгын маягтыг авахдаа дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Урилга илгээж буй этгээдийн үл хөдлөх хөрөнгийн тухай мэдүүлэг;
2. Урилга илгээгч этгээдийн ажлын газраас олгосон орлогын мэдүүлэг эсвэл Үндэсний орлогын агентлагийн орон нутгийн хэлтсээс олгосон дугаар бүхий Хувь хүний орлогоос авах татварын тухай хуулийн 50 дугаар заалтын дагуу татвар төлсөн тухай өмнөх жилийн баримтын хуулбар.

Худалдааны хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн буюу хуулийн этгээд богино хугацаагаар **бизнес-харилцааны зорилгоор** виз мэдүүлэн зорчихыг урьсан урилга нь тусгай маягт байх ба урилгыг илгээгчийн гарын үсэг, тамгатай байх бөгөөд нотариатаар болон гадаадын иргэдийг хянан шалгах байгууллагаас /Болгарын Дотоод хэргийн яамны “Миграция” газар/ баталгаажуулсан байна. Урилгын маягтыг авахдаа дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Худалдаа эрхлэгчдийн бүртгэлийн тухай хуулийн дагуу Бүртгэлийн агентлагаас олгосон хуулийн этгээд/хувь хүний нөхцөл байдлын тухай лавлагаа /хүчинтэй хугацаа 3 сар/
2. Үндэсний орлогын агентлагийн орон нутгийн хэлтсээс урилга илгээгч этгээдэд олгосон дугаар бүхий өмнөх жилийн татвар төлсөн тухай баримтын хуулбар.

Хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуулийн 24 дүгээр заалтын дагуу бүртгэгдсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын урилгаар бизнес харилцааны зорилгоор богино хугацааны виз хүсэхэд тусгай маягт байна.

Урилга илгээгчийн гарын үсэг, тамгатай байх ба нотариатаар болон гадаадын иргэдийг хянан шалгах байгууллагаас /Болгарын Дотоод хэргийн яамны “Миграция” газар/ баталгаажуулсан байх ба дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Болгарын худалдаа аж үйлдвэрийн танхимаас олгосон тухайн төлөөлөгчийн газрын нөхцөл байдлын тухай сертификат /хүчинтэй хугацаа 3 сар/
2. Үндэсний орлогын агентлагийн орон нутгийн хэлтэст бүртгүүлсэн тухай гэрчилгээний хуулбар.

Урилгын маягтыг ДХЯ-ны “Миграция” хэлтсийн хариуцах албанаас болон тухайн албаны мужийн хэсгүүдээс авах боломжтой.

- **Аялалын зорилгыг батлах**

Хувиараа зорчих

Бүгд Найрамдах Болгар Улсад хувиараа зорчих гадаадын иргэнд зориулсан урилга

Бизнес аялал

Бүгд Найрамдах Болгар Улсад бизнес аялал хийх гадаадын иргэнд зориулсан урилга

Соёлын солилцоо

Соёлын яам, эсвэл мужийн захиргааны захидал-урилга

Спорт

Залуучууд, спортын яам, эсвэл хамаарах спорт клубын захидал-урилга

Эмчилгээ

Эмчилгээний болон нөхөн сэргээлтийн тодорхой төлөвлөгөөтэй, эмнэлгийн байгууллагаас зохих журмын дагуу олгосон магадлагаа, өөрийн орны эмнэлгийн оношилгоо

Аялал жуулчлал

- **Нэгдсэн зохион байгуулалттай бус /ганцаарчилсан/ жуулчлал:**

зочид буудлын захиалга;

хоёр талын онгоцны билетийн захиалга /виз мэдүүлэхдээ зөвхөн захиалгыг үзүүлж болох ч виз олгох үед билетийг авч ирнэ/ эсвэл буцаж ирэхэд хангалттай хөрөнгийн чадвартай болохын баталгаа

- **Зохион байгуулалттай /ганцаарчилсан/ жуулчлал:**

илгээгч аялал жуулчлалын байгууллагаас олгосон жуулчлалын ваучер; бүлэг жуулчдын нэрсийн жагсаалт. Зөвхөн тусгай зөвшөөрөлтэй аялал жуулчлалын байгууллага зохион байгуулалттайгаар жуулчдын бичиг баримтыг визэнд өгөх боломжтой юм.

УДААН ХУГАЦААНЫ “D” ВИЗ

Олгох тохиолдлууд

Удаан хугацааны визийг Бүгд Найрамдах Болгар Улсад удаан хугацаагаар болон байнга оршин суухыг хүссэн гадаадын иргэнд олгоно.

Оршин суух хугацаа

6 сар хүртэл хугацаатай 180 хүртэл хоног байх эрхтэй удаан хугацааны визийг Бүгд Найрамдах Болгар Улсад удаан хугацаагаар болон байнга оршин суухыг хүссэн гадаадын иргэнд олгоно. (БНБУ дахь гадаадын иргэдийн тухай хуулийн 15-р зүйлийн 1-р заалтын дагуу)

1 жил хүртэл хугацаатай 360 хүртэл хоног байх эрхтэй удаан хугацааны визийг дараах нөхцөлд олгоно:

- шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ хийж буй гадаадын иргэн буюу нэг хичээлийн жил хүртэлх хугацаатай сургалтын хөтөлбөртэй оюутан;
- мэргэжил дээшлүүлэгч, дадлагажигч;
- гадаадын ажил олгогчийн томилолтоор аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу хяналт, зохион байгуулалттай холбоотой тодорхой даалгавар биелүүлэхээр илгээгдсэн гадаадын иргэн;
- гадаадын ажил олгогчийн томилолтоор Хөрөнгө оуулалтыг дэмжих тухай хуулийн дагуу зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтыг хийхээр томилогдсон гадаадын иргэн.
(БНБУ дахь гадаадын иргэдийн тухай хуулийн 15-р зүйлийн 2-р заалтын дагуу)

Тодорхойлолт

Удаан хугацаагаар зорчих “D” виз нь өөрийн хүчинтэй хугацааны хүрээнд Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэрт олон удаа орж гарах эрх олгоно.

Улсын хянан шалгах байгууллагуудаас гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгосон тохиолдолд удаан хугацаагаар зорчих “D” виз хүчингүй болно.

Мэдүүлгийг хаана өгөх вэ

Удаан хугацаагаар зорчих “D” виз олгохыг хүссэн мэдүүлгийг зөвхөн виз хүсэгчийн байнга оршин суудаг улсад суугаа дипломат болон консулын төлөөлөгчийн газар эсвэл тухайн виз хүсэгчийн байнга оршин суудаг улсад итгэмжлэгдсэн төлөөлөгчийн газруудад өгнө. Онцгой тохиолдолд өөрийн байнга оршин суудаг улсаас өөр гуравдагч оронд хуулийн үндэслэлээр оршин суугаа хүмүүс уг шалтгаанаа үндэслэлтэй бөгөөд өөрийн байнга оршин суудаг улсаа хэзээ ч буцан очих боломжтойг баталсан бол тухайн гуравдагч оронд виз мэдүүлж болох юм.

Виз мэдүүлэгчтэй зайлшгүй ярилцлага хийх

Удаан хугацаагаар зорчих виз олгохыг хүсэн мэдүүлэхэд виз хүсэгчтэй ярилцлага хийх нь зайлшгүй юм. Онцгой тохиолдол гэж байхгүй.

Виз хүсэгчийн бүрдүүлэх бичиг баримтууд

Удаан хугацаагаар зорчих виз олгохыг хүсэн мэдүүлэхдээ виз хүсэгч нь дараах бичиг баримтуудыг бүрдүүлнэ:

1. Виз олгохыг хүссэн мэдүүлэг;
2. Гадаадад зорчиход хүчинтэй баримт бичиг /Хүчинтэй гадаад паспорт/;
3. Гадаад паспортын үндсэн өгөгдлүүд бүхий нүүр хуудасны хуулбар болон өөр виз дарагдсан хуудасны ба/буюу орох зөвшөөрлийн хуулбар;
4. Гадаад паспортын форматтай сүүлийн үеийн өнгөт зураг;
5. **БНБУ дахь гадаадын иргэдийн тухай хуульд** заагдсан шаардлага болон **уг хуулийн тодотгол журмуудын** дагуух удаан хугацаагаар зорчих виз хүсэх үндэслэл болох баримт бичгүүд ба мөн түүнчлэн нийт зардал болон оршин байхад хүрэлцэхүйц санхүүгийн боломжтойг харуулсан бичиг баримтуудын эх болон хуулбар хувь.

Бусад шаардлагууд

Удаан хугацаагаар үргэлжлүүлэн оршин суух зөвшөөрөл хүссэн этгээд нь оршин суух тодорхой **орон сууцтай, эрүүл мэндийн даатгалтай ба шимтгэл төлсөн байх нь зайлшгүй** бөгөөд оршин суух хугацаандаа нийгмийн тусламжийн системд хандахааргүйгээр, БНБУ-ын хууль журмын дагуу заагдсан сарын цалингийн доод хэмжээ,

эсвэл тэтгэврийн доод хэмжээнээс багагүй бөгөөд зардлаа **бүрэн хариуцах хэмжээний хөрөнгийн баталгаатай** байна.

Визний мэдүүлгийг анх өгөх

Оршин суух зөвшөөрөл хүсэн анх мэдүүлэхэд иргэний харьяалалтай **18 нас хүрсэн этгээд** иргэний харьяаллын дагуух өөрийн улсаас, эсвэл өөрийн байнга оршин суудаг улсаас олгосон **цагдаагийн газрын тодорхойлолт** авчрах шаардлагатай.

Тухайн улсад нэвтрэхэд юу шаардагдах вэ

Гадаадын иргэн Бүгд Найрамдах Болгар Улсад нэвтрэхдээ гадаадад зорчиход хүчинтэй бичиг баримттай, эсвэл уг бичиг баримтыг орлох бичиг баримттай, мөн шаардлагатай бол визтэй байна.

Виз олголт

Болгарын виз авахыг хүссэн аливаа гадаадын иргэн дараах шаардлагуудыг хангасан **гадаадад зорчиход хүчинтэй бичиг баримттай** байна:

- хүчинтэй хугацаа нь Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэрээс гарахаар төлөвлөсөн өдрөөс хойш хамгийн багадаа гурван сар байх ба хэрэв олон удаа зорчих бол Бүгд Найрамдах Болгар Улсын нутаг дэвсгэрээс сүүлийн удаа гарахаар төлөвлөсөн өдрөөс хойш хамгийн багадаа гурван сар байна;
- хамгийн цөөндөө виз дарж болохоор хоёр хоосон хуудастай байна;
- өмнөх 10 жилийн дотор олгогдсон байна.

Визийг Бүгд Найрамдах Болгар Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газраас олгоно.

Виз олгохыг хүсэн мэдүүлэг өгөх

Виз олгохыг хүсэн мэдүүлэг нь тодорхой маягт байх бөгөөд мэдүүлгийг биечлэн эсвэл хүмүүнлэгийн ямар нэг шалтгаантай тохиолдлоос бусад үед итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан зорчихоор төлөвлөсөн өдрөөс 3 сараас ихгүй хугацааны өмнө өгнө.

Мэдүүлгийн маягтыг дараах холбоосоор орон татаж болно.

<http://www.mfa.bg/en/pages/133/index.html>

Мэдүүлгийн маягтын асуулга бүрийг бүрэн бөглөсөн байх бөгөөд мэдүүлэгчийн гарын үсэг зайлшгүй зурагдсан байна.

Бага насны хүүхэд эсвэл хуулийн хариуцлага хүлээх чадваргүй этгээдэд виз олгохыг хүссэн бол мэдүүлгийг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид эсвэл тэдгээрийн биечлэн итгэмжилсэн этгээд өгнө.

Визийн мэдүүлгийг бөглөхөд тавигдах шаардлагууд

Асуулга бүрийг дармал үсгээр гаргацтай бөглөсөн байна. Нэрсийг гадаад паспортад бичигдсэн дагуу латин үсгээр бичсэн байна. Бусад мэдээллийг англи, эсвэл болгар хэлээр бичиж бөглөнө.

Мэдүүлэгт мэдүүлэгч өөрөө гарын үсэг зурсан байх шаардлагатай.

Европын холбооны иргэдийн гэр бүлийн гишүүд визний мэдүүлгийн зөвхөн гэр бүлийн ямар холбоотой талаарх асуулгуудыг бөглөнө.

“D” виз мэдүүлэхэд биечлэн байх шаардлагатай

Удаан хугацааны виз олгохыг хүссэн этгээд зайлшгүй биечлэн мэдүүлэх шаардлагатай. Онцгой тохиолдол гэж байхгүй.

Виз хүсэгчийн мэдүүлэгт зайлшгүй хавсаргагдах бичиг баримтууд

1. Гадаадад зорчиход хүчинтэй баримт бичгийн эхний хуудасны хуулбар;
2. Хэрэв байгаа бол хамгийн сүүлийн болгарын болон шенгений виз бүхий, эсвэл Их Британи болон АНУ-д зорчих виз бүхий хуудасны хуулбар;
3. Өнгөт 3,5 x 4,5 хэмжээтэй цайвар дэвсгэртэй цээж зураг (паспортад бичигдсэн хүүхдийн цээж зураг мөн адил байна). Зураг дээрх нүүр тод, том, эгц урагш харсан байх ба зургийн 70-80 хувийг эзэлсэн байна. Нүд улаан биш байна. Бараан өнгийн нүдний шилтэй зураг, мэргэжлийн бус байдлаар авсан буюу сонирхогчийн зурагнаас хэрчиж авсан зураг **ХҮЛЭЭЖ АВАХГҮЙ**;
4. Европын холбооны гишүүн орнуудад хүчинтэй, зорчих хугацааг бүрэн хамарсан, визэнд заагдсан Болгарт байх хугацаанд эх оронд нь буцаах, эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэх болон яаралтай эмчилгээ хийх шаардлагатай үед бүх зардлыг нөхөх боломжтой эрүүл мэндийн даатгал. Даатгалын хэмжээ 30 мянган еврогоос багагүй байх шаардлагатай;
5. Онгоцны эсвэл галт тэрэгний тасалбар (эх болон хуулбар хувь), эсвэл явах, буцах өдрүүдийг тодорхой заасан хоёр талын тасалбарын баталгаажуулсан захиалгын хуудас;
6. Автомашин явах бол техник хэрэгслийн гэрчилгээний хуулбар;
7. Эцэг эх, албан ёсны асран хамгаалагчгүйгээр зорчиж буй насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд нэмэлтээр дараах зүйлс шаардагдана:
 - Төрсний гэрчилгээний хуулбар;
 - Эцэг эх/тэжээгчид хоёулаа, эсвэл эцэг эх/тэжээгчийн аль нэг насанд хүрээгүй хүүхэдтэйгээ хамт явахгүй тохиолдолд хүүхдэд хийлийн чанадад явахыг зөвшөөрсөн бол нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл гаргаж өгөх ба түүний хуулбар.

Хоноглох, хооллох болон тээврийн зардлыг хаах баталгааг зайлшгүй гаргах шаардлагаас чөлөөлөгдөх тохиолдлууд:

- Европын холбоо, Европын эдийн засгийн бүсийн орнууд болон Швейцарын холбооны улсын иргэдийн гэр бүлийн, эсвэл өрх гэрийн гишүүд;
- Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Улсын дүрвэгсдийн асуудал хариуцсан агентлагаас бичгээр зөвшөөрөл олгосонд үндэслэн, Бүгд Найрамдах Болгар Улсад дүрвэгчийн статус олголтын хүрээнд, эсвэл орогнол хүсэн гэр бүлийг нэгтгэх зорилгоор удаан хугацааны виз хүссэн этгээд;
- Дипломат ба албан паспорттай хүмүүс.

Эрүүл мэндийн даатгал хийлгэсэн байх зайлшгүй шаардлагаас чөлөөлөгдөх тохиолдлууд:

- Европын холбоо, Европын эдийн засгийн бүсийн орнууд болон Швейцарын холбооны улсын иргэдийн гэр бүлийн, эсвэл өрх гэрийн гишүүд;
- Дипломат ба албан паспорттай хүмүүс;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 108-р конвенцийн дагуу зохих шалгуурыг хангасан далайчид хилээр транзит хийн гарах зорилгоор богино хугацааны виз хүсэн мэдүүлэхэд;

- Нийгэмд эзлэх, эсвэл албан байр суурь нь тодорхой бөгөөд даатгалд хамрагдсан гэж үзэж болохоор хүмүүс, эсвэл урьдчилан таашгүй нөхцөл байдлаас үүдэн гарах зардлыг хариуцах чадвартай этгээдүүд.

Визний мэдүүлгийг боловсруулах төлбөрөөс чөлөөлөгдөх тохиолдлууд:

- Виз хүссэн мэдүүлэг өгөх өдөр хүртэл 6 нас хүрээгүй гадаадын иргэд;
- Болгарын иргэд болон ЕХ-ны иргэдийн гэр бүлийн гишүүд.